

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 02

Багануур дүүрэг

Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 6,76 км урт 110 кВ-н агаарын шугамыг барих нийт төсөв 3922,0 сая. Төр хувийн хэшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн МЕСЕС ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Нийслэлийн төсвөөс 2174,0 сая төгрөг баталсан. Үүнээс 2022 онд 674,1 сая, 2023 онд шилжих төсөвт 1500,0 сая төгрөг баталсан. Гүйцэтгэгч сонгон шалгаруулалтаар Энх Өглөө ХХК 2022 оны 9 сарын 5 өдөр НЗДТГ-тай гэрээ байгуулан бүтээн байгуулалтыг эхлүүлснээр зураг төслийн трассын дагуу өгөгдсөн координатуудаар улаан шугам татаж, тулгууруудын байрлалыг тодорхойлж, тулгуур босгох 40 суурийн барилга угсралтын ажлуудыг гүйцэтгэж, 2022 оны 674,1 сая төгрөгийн төсөвтэй Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээт ажил бүрэн хийгдэж дууссан. МЕСЕС ХХК-ий зүгээс 526,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар суурийн барилгын ажил хийж, 500,0 сая төгрөгийн бетон болон төмөр тулгуур бэлтгэх ажил хийсэн байна. Нийт 1700,1 сая төгрөгийн бүтээн байгуулалт хийгдсэн байна.

БОЛОВСРУУЛСАН:

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН

АЛБАНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.МӨНГӨНХУЯГ